



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/218/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Архангай аймаг

2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: nerguibaatar@audit.gov.mn

Аудитор П.Энхжаргал

Утас: 99743112

Цахим хаяг: enkhjargal@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан.....	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	8
3.8 Аудитын гол асуудал	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	9
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	9
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	9
4. Аудитын илрүүлэлт	10
4.1 Зөвлөмж	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

1.Аудитын санал дүгнэлт



2022.02.22 № 50
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1271715640.00</u>	<u>930410144.00</u>
33	АВЛАГА	1271715640.00	930410144.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1066250.00	1000000.00
335	Бусад авлага	1270649390.00	929410144.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1270649390.00	929410144.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1271715640.00</u>	<u>930410144.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1271715640.00</u>	<u>930410144.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1271715640.00	930410144.00
512	Хуримтлагдсан үр дүн	1271715640.00	930410144.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1271715640.00	1270649390.00
51220	Тайлант үеийн үр дүн		-340239246.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1271715640.00</u>	<u>930410144.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>672669602.58</u>	<u>707853795.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>19875802.58</u>	<u>5954795.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	19875802.58	5954795.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19785802.58	5954795.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19785802.58	5954795.00
120009	Бусад орлого	90000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>652793800.00</u>	<u>701899000.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	360838500.00	0.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	360838500.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	291955300.00	701899000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	39390300.00	61899000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	252565000.00	64000000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>1091514077.58</u>	<u>1048093041.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1091514077.58</u>	<u>1048093041.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24971600.00	36364300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2565000.00	3254000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2565000.00	3254000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22406600.00	33110300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13319100.00	22749300.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9087500.00	10361000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1066542477.58	1011728741.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	261576650.00	302345586.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	261576650.00	302345586.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19875802.58	5954795.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19875802.58	5954795.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	92666400.00	45189114.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	92666400.00	45189114.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	692423625.00	658239246.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	692423625.00	658239246.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-418844475.00	-340239246.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15197800.00	0.00
225002	Найдваргүй авлагын алдагдал	15197800.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-15197800.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-434042275.00	-340239246.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,271,715,640.00	1,271,715,640.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,271,715,640.00	1,271,715,640.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,271,715,640.00	1,271,715,640.00
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,271,715,640.00	1,271,715,640.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,066,250.00	-1,066,250.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,270,649,390.00	1,270,649,390.00
D08	Тайлант үеийн үр дүн	-340,239,246.00	-340,239,246.00
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	930,410,144.00	930,410,144.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1366159477.58	707853795.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	713365677.58	5954795.00
120	Нийтлэг татварын бус орлого	713365677.58	5954795.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	713275677.58	5954795.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	693489875.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19785802.58	5954795.00
120009	Бусад орлого	90000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	652793800.00	701899000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	360838500.00	0.00

Архангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	360838500.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	291955300.00	701899000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	39390300.00	61899000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	252565000.00	640000000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1366159477.58	1367093041.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1366159477.58	1367093041.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24971600.00	36364300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2565000.00	3254000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2565000.00	3254000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22406600.00	33110300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13319100.00	22749300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9087500.00	10361000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1341187877.58	1330728741.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600576650.00	620345586.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	600576650.00	620345586.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19875802.58	5954795.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19875802.58	5954795.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	27245550.00	45189114.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	423350.00	0.00
213404	Хөрөнгийн	26822200.00	45189114.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	693489875.00	659239246.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	693489875.00	659239246.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	-659239246.00
14	Бусад эх үүсвэр	0.00	659239246.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	659239246.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	736,485,150.00	656,709,886.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	736,485,150.00	656,709,886.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,447,150.00	36,364,300.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,548,150.00	3,254,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,548,150.00	3,254,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,899,000.00	33,110,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,538,000.00	22,749,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,361,000.00	10,361,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	670,038,000.00	620,345,586.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	670,038,000.00	620,345,586.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	670,038,000.00	620,345,586.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	736,485,150.00	656,709,886.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	674,586,150.00	623,599,586.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	674,586,150.00	623,599,586.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	61,899,000.00	33,110,300.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	61,899,000.00	33,110,300.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харъяалагдах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харъяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ил тод нээлттэй, шударга байх зарчмыг баримталж иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэхэд бидний эрхэм зорилго оршино” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дотоод хяналт, хяналт шинжилгээ, хариуцсан мэргэжилтэн 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийж тайланг байгууллагын даргад ирүүлснийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 670.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 341.3 сая төгрөгөөр буюу 26.8 хувиар буурсан бөгөөд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлагын данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Авлага	1,271.7	930.4	-341.3	-26.8
Нийт хөрөнгө	1,271.7	930.4	-341.3	-26.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,271.7	930.4	-341.3	-26.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,271.7	930.4	-341.3	-26.8

- *Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 26.8 хувиар буурсан байна.*

Авлага данс нь 1,271.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 317.9 сая төгрөгийн зээл олгож, 659.2 сая төгрөгийн авлага барагдуулснаар 930.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 26.8 хувиар буурсан байна.*

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 930.4 сая төгрөг байгаа нь тайлант хугацааны үр дүн 341.3 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 652.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 21.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардлыг 674.6 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 17 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 674.6 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 640.0 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 623.6 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгт зарцуулан 16.4 сая төгрөгийг, дэлхийн банкны санхүүжилтээр 61.9 сая төгрөгийн санхүүжилтээс 33.1 сая төгрөгийг зарцуулж 28.8 сая төгрөгийг нийт 45.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 83.3 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд нийт 736.5 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 656.7 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 89.2 хувь байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байдаг.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар зарим арга хэмжээний тухай” засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймгийн ХЭДСан нь 2021 онд нийт 389.7 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 126 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 11.1 хувь буюу 79.8 сая төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 заалт зөвлөмж хүргүүлснээс шилэн дансны мэдээллийг хугацаанд байршуулах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг нягтлан шалгах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 172.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснийг материаллаг бус гэж үнэлэн давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.1 Зөвлөмж

Зээлийн эргэн төлөлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд төвлөрүүлэхээр төлөвлөсөн орлогыг 659.2 сая төгрөг төвлөрүүлж 172.0 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41.2.1-д заасныг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/			
				Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Албан шаардлага	Тоо	Дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал							
1	ХЭДСан	1	172.0	0	0	1	172.0
Дүн		1	172.0	0	0	1	172.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал							
1	ХЭДСан	0	0	0	0	0	0
Дүн		0	0	0	0	0	0
Нийт дүн		1	172.0	0	0	0	0